



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар Х/303

Булган сум

Насны I, II ангийн ойд арчилгааны
огтлолт хийх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны Ойн ангид ойн таварлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх, төсөл арга хэмжээний 30,400,000 (гучин сая дөрвөн зуун мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх ажлыг зохион байгуулж, хавсралтад тусгагдсан арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг сум дундын Ойн ангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний "Ойн таварлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх (70га, Бугат, Хишиг-Өндөр, Орхон, Хангал, Хутаг-Өндөр, Баян-Агт, Сэлэнгэ сум)" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ




Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010397

05

Аймгийн Засаг даргын 2024 оны
..... дүгээр сарын 01-ний өдрийн А/303 дугаар
захирамжийн хавсралт



Ойн ангийн насны I, II ангийн ойд арчилгааны
огтлолт хийх зардлын хуваарилалт

д/д	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг (төг)	Эрх шилжүүлсэн Ойн ангийн даргын нэр
1	2	3	4
1	Булган сум дундын Ойн анги	11,975,000	Б.Алтансүх
2	Хялганат сум дундын Ойн анги	11,975,000	М.Нямжаргал
3	Хутаг-Өндөр сум дундын Ойн анги	6,450,000	Ш.Даваахүү
Нийт		30,400,000	